

ӨМНӨХ ҮГ

Монголын Хүн Ам ба Хөгжил Нийгэмлэг, Хүн Амын Сургалт Судалгааны Төвтэй хамтран НҮБ-ын Хүн Амын Сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр “Монголын Хүн Амын Сэтгүүл”-ийн 11 дэх дугаарыг бэлтгэн эрхэм уншигч та бүхэнд толилуулж байна.

Сэтгүүлийн “*ᠨᠣᠶ᠋ᠠᠭᠡᠭᠡᠠᠭᠠ*” хэсгээс Монголын хүн ам зүйн цонх, түүний эдийн засагт үзүүлэх нөлөө сэдэвт сонирхолтой бүтээлтэй танилцахаас гадна Улаанбаатар хотын ядууралд шилжих хөдөлгөөний үзүүлж буй нөлөө, шилжигчдийн нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлууд, тэдгээрийг шийдвэрлэх арга замын талаар судлаачдын гаргасан дүгнэлт, зөвлөмжүүдийг сонирхож болно. Судлаачдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор энэ дугаарын “*ᠨᠣᠳᠠᠭᠡᠭᠡᠠᠭᠠ*” хэсэгт Түүвэрлэлтийн онол, арга зүйн зарим асуудлыг танилцуулж байна. Харин “*ᠴᠦᠭᠡ ᠠᠶᠢᠶᠡ*” хэсгээс та бүхэн Хүн амын нийгмийн хамгааллын талаар судлаачийн санал, бодлыг уншаарай.

Монгол Улсын хүн ам, хөгжлийн асуудлаар эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оюун ухаан, мэдлэг чадвараа зориулж буй нийт эрдэмтэн судлаачид, мэргэжилтэн, оюутан, залуучууд та бүхэндээ болон сэтгүүлийн дугааруудыг бэлтгэн хэвлэхэд байнгын дэмжлэг, туслалцаа үзүүлж байдаг НҮБ-ын Хүн Амын Сангийн Суурин төлөөлөгчийн Газарт сэтгүүлийн редакцийн нэрийн өмнөөс гүн талархал илэрхийлье.

Эрхэм уншигч таны оюуны мэлмий тань тэлэх болтугай.

РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ